



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/486

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Газрын тусгай үйлчилгээний албаны тусгай зориулалтын автомашин, механизмын троссон шүүр, плагны резин, агаарын хөлгийн хөдөлгүүр халаагчийн хоолой нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

|                           |                |   |
|---------------------------|----------------|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Д.Эрдэнэбаатар | Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын газрын дарга  |
| Нарийн бичгийн дарга:     | Б.Санчир       | Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн   |
| Гишүүд:                   | Ц.Уянга        | Нисэх буудлуудын удирдах газрын Нисэх буудлуудын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
|                           | С.Чинзориг     | Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл   |
|                           | Б.Энх-Амгалан  | Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл   |

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Эрдэнэбаатар/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН